



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/33/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhant@audit.gov.mn">Batsaikhant@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Ugtakhbayarj@audit.gov.mn">Ugtakhbayarj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Г.Үүрийнтуяа Утас: 70593208 Цахим хаяг: <a href="mailto:Uurintuyag@audit.gov.mn">Uurintuyag@audit.gov.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....</b>	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>3</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	/төгрөгөөр/ .....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	/төгрөгөөр/ .....5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	/төгрөгөөр/ .....6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	/төгрөгөөр/ .....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>10</b>
3.1 Төлбөрийн акт .....	10
3.2 Албан шаардлага.....	10
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>16</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ШИНЭБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг бөгөөд өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалингийн зардалд давтан тооцоолол хийхэд анхан шатны баримтаас 0.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Тус алдааг залруулаагүй тул цалингийн зардлын дүнг баталгаажуулах боломжгүй, энэ нь шинж чанарын хувьд материаллаг бөгөөд санхүүгийн тайланд дангаараа нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 20 дугаар зүйлийн 20.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.6-т заасан тус тус заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн байх мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд улсын төсвөөс 789.5 сая төгрөгийн санхүүжилт орж ирэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 371,613.3 мянган төгрөгийг 182,612.7 мянган төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн бол 235,310.1 мянган төгрөгийн батлагдсан

4826050216

санхүүжилт дутуу олгогдсон байна.

Уг үйл явцуудыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

#### **Аудитын гол асуудал**

Төсөв хэтрүүлэн зарцуулснаас үүдэн богино хугацаат өр төлбөрийн ажилчидтай холбогдсон өглөг 11.6 сая төгрөг гарсан бөгөөд энэ нь тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажсан өр төлбөр байна. Харин цалингийн давтан тооцооллоор уг өр төлбөрөөс гадна 0.6 сая төгрөгийн зөрүү илэрсэн ба үүнийг баталгаажуулж, залруулах боломжгүй зөрчил гэж үзсэн.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 51 арга хэмжээг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 78.0 хувьтай гэж тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>3,700,000.00</b>	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,700,000.00	-
31210	Төгрөг	3,700,000.00	-
31218	Ахмадын сангийн харилцах	3,700,000.00	-
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	<b>3,700,000.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	3,700,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>65,792,630.00</b>	<b>66,103,280.00</b>
35100	Түүхий эд материал	2,206,900.00	2,206,900.00
35110	Тусгай зориулалттай материал	1,978,900.00	1,978,900.00
35130	Эм боох материал	228,000.00	228,000.00
35400	Хангамжийн материал	63,585,730.00	63,896,380.00
35410	Бичиг хэргийн материал	4,333,550.00	3,084,950.00
35420	Аж ахуйн материал	56,693,680.00	56,663,430.00
35430	Сэлбэг хэрэгсэл	230,000.00	190,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,170,000.00	-
35450	Барилгын засварын материал	1,158,500.00	3,958,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	-
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>69,492,630.00</b>	<b>69,803,280.00</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>210,385,509.70</b>	<b>185,739,410.12</b>
39200	Биет хөрөнгө	210,343,843.15	185,739,410.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,495,000.00	11,495,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	-	(574,749.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,770,800.00	75,770,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(4,125,000.00)	(11,702,079.96)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	107,483,563.92	118,070,293.92
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(32,061,440.12)	(54,539,441.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,309,002.00	59,634,624.71
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(6,528,082.65)	(12,415,036.97)
39300	Биет бус хөрөнгө	41,666.55	-
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(1,458,333.45)	(1,500,000.00)
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>210,385,509.70</b>	<b>185,739,410.12</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>279,878,139.70</b>	<b>255,542,690.12</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>11,619,278.17</b>
41300	Өглөг	-	11,619,278.17
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,654,318.17
41311	Цалингийн өглөг	-	614,758.00
41312	НДШ-ийн өглөг	-	193,314.44
41313	ХАОАТ-ын өглөг	-	846,245.73
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	9,964,960.00
413207	Албан томилолтын өглөг	-	7,220,000.00
413213	Бусад зардлын өглөг	-	2,744,960.00
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	-	<b>11,619,278.17</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>279,878,139.70</b>	<b>243,923,411.95</b>
51200	Хуримтлагдсан үр дүн	279,878,139.70	243,923,411.95
51210	Өмнөх үеийн үр дүн	121,551,113.45	279,878,139.70
51220	Тайлант үеийн үр дүн	158,327,026.25	(35,954,727.75)
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>279,878,139.70</b>	<b>243,923,411.95</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>279,878,139.70</b>	<b>255,542,690.12</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>13</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>617,488,106.64</b>	<b>669,066,486.80</b>
1310	Улсын төсвөөс	500,123,100.00	554,226,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	500,123,100.00	554,226,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,365,006.64	114,840,486.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	40,365,006.64	94,840,486.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	77,000,000.00	20,000,000.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	<b>118,563,611.00</b>	<b>11,371,852.71</b>
1200	Нийтлэг татварын бус орлого	118,563,611.00	11,371,852.71
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	104,649,631.00	11,227,452.71
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	13,913,980.00	144,400.00
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>736,051,717.64</b>	<b>680,438,339.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>566,229,691.39</b>	<b>716,393,067.26</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	405,173,921.72	514,356,998.83
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	259,332,685.00	311,258,546.79
210101	Үндсэн цалин	153,518,160.00	174,685,838.36
210102	Нэмэгдэл	77,186,599.00	87,043,426.15
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	9,305,000.00	33,295,324.28
210104	Урамшуулал	19,322,926.00	16,233,958.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,201,103.28	40,132,831.75
210201	Тэтгэврийн даатгал	21,896,747.81	28,011,977.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,576,087.96	3,064,636.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,288,044.05	1,460,513.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,288,044.05	1,545,627.81
210205	Эрүүл мэндийн даатгал	5,152,179.41	6,050,076.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,403,760.00	8,222,160.00
210303	Цэвэр, бохир ус	463,000.00	287,000.00
210304	Байрны түрээс	4,940,760.00	7,935,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,289,983.89	12,402,050.00
210401	Бичиг хэрэг	2,358,850.00	3,553,650.00
210402	Тээвэр, шатахуун	8,398,460.00	6,461,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,534,123.89	1,550,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	94,960.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	483,040.00	836,950.00
210408	Бараа материал актласны зардал	420,550.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,851,800.00	110,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,425,000.00	-
210604	Урсгал засвар	1,426,800.00	110,500.00
2107	Томилолт, зочны зардал	13,702,800.00	12,980,000.00
210702	Дотоод албан томилолт	13,702,800.00	12,980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,983,052.80	68,238,417.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,214,700.00	68,238,417.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,352.80	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,408,736.75	61,012,493.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,397,452.00	22,972,441.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	7,619,300.00	1,481,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	25,391,984.75	36,558,452.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,055,769.67	202,036,068.43

2132	Бусад урсгал шилжүүлэг	29,641,500.00	18,100,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	17,530,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,111,000.00	18,100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	131,414,269.67	183,936,068.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	131,091,471.67	182,612,715.87
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	322,798.00	1,323,352.56
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>566,229,691.39</b>	<b>716,393,067.26</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>169,822,026.25</b>	<b>(35,954,727.75)</b>
<b>14</b>	<b>ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
<b>23</b>	<b>Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл</b>	-	-
<b>24</b>	<b>Гадаад зээлийн үндсэн төлбөр</b>	-	-
<b>25</b>	<b>Гадаад валютын ханшийн зөрүү</b>	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	11,495,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,495,000.00	-
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>11,495,000.00</b>	-
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>158,327,026.25</b>	<b>(35,954,727.75)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>13</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>617,488,106.64</b>	<b>669,066,486.80</b>
1310	Улсын төсвөөс	500,123,100.00	554,226,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	500,123,100.00	554,226,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,365,006.64	114,840,486.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	40,365,006.64	87,695,045.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	77,000,000.00	27,145,441.00
<b>12</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</b>	-	-
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>617,488,106.64</b>	<b>669,066,486.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>556,877,306.64</b>	<b>672,766,486.80</b>
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395,821,536.97	467,030,418.37
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	259,332,685.00	311,154,492.46
210101	Үндсэн цалин	153,518,160.00	174,581,784.03
210102	Нэмэгдэл	77,186,599.00	87,043,426.15
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	9,305,000.00	33,295,324.28
210104	Урамшуулал	19,322,926.00	16,233,958.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,201,103.28	39,997,348.91
210201	Тэтгэврийн даатгал	21,896,747.81	27,876,494.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,576,087.96	3,064,636.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,288,044.05	1,460,513.69
210204	Ажилгүйдлийн даатгал	1,288,044.05	1,545,627.81
210205	Эрүүл мэндийн даатгал	5,152,179.41	6,050,076.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,403,760.00	5,477,200.00
210303	Цэвэр, бохир ус	463,000.00	287,000.00
210304	Байрны түрээс	4,940,760.00	5,190,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,392,783.89	8,482,641.00
210401	Бичиг хэрэг	3,598,100.00	2,193,350.00
210402	Тээвэр, шатахуун	9,048,460.00	4,186,441.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,534,123.89	1,550,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	119,960.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,092,140.00	552,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,824,300.00	3,444,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	749,800.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,098,500.00	-
210604	Урсгал засвар	1,725,800.00	2,695,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,702,800.00	5,760,000.00
210702	Дотоод албан томилолт	13,702,800.00	5,760,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,983,052.80	68,158,895.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,214,700.00	68,158,895.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,352.80	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,981,052.00	24,555,041.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,921,752.00	23,073,441.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	8,059,300.00	1,481,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,055,769.67	205,736,068.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,641,500.00	18,100,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	17,530,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,111,000.00	18,100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	131,414,269.67	183,936,068.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	131,091,471.67	182,612,715.87
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	322,798.00	1,323,352.56
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,700,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,700,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>556,877,306.64</b>	<b>672,766,486.80</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>60,610,800.00</b>	<b>(3,700,000.00)</b>
<b>14</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	-	-
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>60,610,800.00</b>	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	60,610,800.00	-
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	60,610,800.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	60,610,800.00	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>60,610,800.00</b>	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>	<b>(60,610,800.00)</b>	-
<b>9</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-	-
24	Гадаад зээлийн үндсэн төлбөр	-	-
25	Гадаад валютын ханшийн зөрүү	-	-
<b>10</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	-	<b>(3,700,000.00)</b>
<b>14</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,700,000.00</b>	<b>3,700,000.00</b>
<b>15</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,700,000.00</b>	-

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>121,551,113.45</b>	<b>121,551,113.45</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	121,551,113.45	121,551,113.45

4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	158,327,026.25	158,327,026.25
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
11	<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>279,878,139.70</b>	<b>279,878,139.70</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	279,878,139.70	279,878,139.70
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
19	<b>Тайлант үеийн үр дүн</b>	-	-	<b>(35,954,727.75)</b>	<b>(35,954,727.75)</b>
20	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>243,923,411.95</b>	<b>243,923,411.95</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-	-
11100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл	-	-	-
11200	Кассын оны эхний үлдэгдэл	-	-	-
12	Татварын бус орлого	789,536,100.00	371,613,284.13	417,922,815.87
12000	Нийтлэг татварын бус орлого	992,500.00	-	992,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	992,500.00	-	992,500.00
12200	Тусламжийн орлого	788,543,600.00	371,613,284.13	416,930,315.87
122005	Төсвөөс санхүүжих	788,543,600.00	371,613,284.13	416,930,315.87
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	789,536,100.00	371,613,284.13	417,922,815.87
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	789,536,100.00	371,613,284.13	417,922,815.87
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	787,036,100.00	371,113,284.13	415,922,815.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	617,953,500.00	293,174,594.80	324,778,905.20
210101	Үндсэн цалин	337,246,800.00	174,581,784.03	162,665,015.97
210102	Нэмэгдэл	183,566,400.00	69,082,423.77	114,483,976.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,907,200.00	33,276,429.00	15,630,771.00
210104	Урамшуулал	48,233,100.00	16,233,958.00	31,999,142.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,537,500.00	37,716,794.33	38,820,705.67
210201	Тэтгэврийн даатгал	52,045,500.00	25,728,207.11	26,317,292.89
210202	Тэтгэмжийн даатгал	6,123,200.00	3,026,846.00	3,096,354.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,061,400.00	1,460,513.69	1,600,886.31
210204	Ажилгүйдлийн даатгал	3,061,400.00	1,526,732.53	1,534,667.47
210205	Эрүүл мэндийн даатгал	12,246,000.00	5,974,495.00	6,271,505.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,403,800.00	5,477,200.00	1,926,600.00
210303	Цэвэр, бохир ус	758,300.00	287,000.00	471,300.00
210304	Байрны түрээс	6,645,500.00	5,190,200.00	1,455,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,746,600.00	4,296,200.00	14,450,400.00
210401	Бичиг хэрэг	8,967,900.00	2,193,350.00	6,774,550.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	-	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,787,800.00	1,550,450.00	3,237,350.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,990,900.00	552,400.00	2,438,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,710,000.00	1,710,000.00	2,000,000.00
210702	Дотоод албан томилолт	3,710,000.00	1,710,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	54,203,100.00	27,256,895.00	26,946,205.00
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	52,536,900.00	27,256,895.00	25,280,005.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	179,600.00	-	179,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	89,800.00	-	89,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,396,800.00	-	1,396,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,481,600.00	1,481,600.00	7,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	-	2,000,000.00
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	6,481,600.00	1,481,600.00	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500,000.00	500,000.00	2,000,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	500,000.00	2,000,000.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
12100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл			
12200	Кассын дансны эцсийн үлдэгдэл			

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)</b>	<b>113,517,134.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>113,517,134.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>95,917,134.24</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>17,979,897.66</b>
210102	Нэмэгдэл	17,961,002.38
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	18,895.28
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,280,554.58</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,148,287.65
210202	Тэтгэмжийн даатгал	37,790.54
210204	Ажилгүйдлийн даатгал	18,895.28
210205	Эрүүл мэндийн даатгал	75,581.11
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,186,441.00</b>
210402	Тээвэр, шатахуун	4,186,441.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,444,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	749,800.00
210604	Урсгал засвар	2,695,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,050,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,050,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>40,902,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,902,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,073,441.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,073,441.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,600,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,600,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,600,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)</b>	<b>113,517,134.24</b>
<b>13</b>	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>113,517,134.24</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>113,517,134.24</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	86,371,693.24

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	27,145,441.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-
<b>11000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-
<b>12000</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 214,985.5 мянган төгрөгийн нийт 6 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,647.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 370.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 213,575.0 мянган төгрөгийн 4 албан шаардлагыг тус тус хүргүүлээ.

#### Залруулсан алдаа:

Аудитаар нийт 1,647.2 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайланд бусад зардлын өглөгийг дутуу тайлагнасан.

#### Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 213,945.0 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрч дараах байдлаар шийдвэрлэлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

##### Илрүүлэлт:

Аудитаар автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлаагүй, шатахууны зардлыг 370.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм" заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Норм хэтрүүлэн олгосон 370.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг баталгаажуулж гүйлгээ хийсэн нягтлан бодогч болон холбогдох эд хариуцагч нярваар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь 100080000955 тоот дансанд 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор төвлөрүүлэх.

#### 3.2 Албан шаардлага

1. Цалин, хөлс нэмэгдэл урамшуулал буруу тооцоолсонтой холбоотой

##### Илрүүлэлт:

Аудитаар анхан шатны баримтаас цалингийн зардлыг 606.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх (*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), 6.4.8-д (*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*), 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 20.2-т (*Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо дахь мэдээлэл нь холбогдох ишидвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна.*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.6-т (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*) заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Аудитаар илэрсэн цалингийн зөрүүг шалгаж, холбогдох авлагыг тайлагнаж, барагдуулах, анхаарч ажиллах.

2. Анхан шатны баримт бүрдэлтэй холбоотой

##### Илрүүлэлт:

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар бүрдэл дутуу анхан шатны баримтаар 160.0 мянган төгрөгийн шатахууны талон олгож, зардлыг бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.7-д (*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*) заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй, санхүүгийн тайланд тусгахгүй байх, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.

### 3. Эдийн засгийн ангилалтай холбоотой

#### Илрүүлэлт:

Аудитаар батлагдсан эдийн засгийн ангилал зөрчин 1,104.6 мянган төгрөгийн тээвэр, шатахууны зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас төлж төсвийг хяналтгүй зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*) заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах.

### 4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

#### Илрүүлэлт:

Аудитаар Тайлант хугацаанд байршуулбал зохих 211,703.8 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн (Шилэн дансны зарчим) 4.1.3-т (*тогтоосон хугацаанд, тогтмол, иуурхай мэдээлдэг байх*) заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 99.5 хувийг залруулагдаагүй, 0.5 хувийг залруулсан алдаа эзэлж байна. Нийт 213,945.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 211,703.8 мянган төгрөг нь нийцлийн аудитын асуудал, 2,241.2 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 2,241.2 мянган төгрөгийн зөрчлөөс 606.6 мянган төгрөгийн цалингийн зөрүүг баталгаажуулах боломжгүй, энэ нь шинж чанарын хувьд материаллаг бөгөөд санхүүгийн тайланд дангаараа нөлөөтэй боловч өргөн тархаагүй учир “ХЯЗГААРЛАЛТАЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд бусад зардлын өглөгөг дутуу тайлагнасан	1	1,647.2			1	1,647.2	1	1,647.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,647.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,647.2</b>	<b>1</b>	<b>1,647.2</b>	<b>0</b>	<b>0</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлаагүй, шатахууны зардлыг хэтрүүлэн зарцуулсан.	1	370.0	1	370.0						
Анхан шатны баримтаас цалингийн зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	606.6			1	606.6				
Бүрдэл дутуу анхан шатны баримтаар шатахууны талон олгож, зардлыг бүртгэсэн.	1	160.0			1	160.0				
Батлагдсан эдийн засгийн ангилал зөрчин тээвэр, шатахууны зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас төлж төсвийг хяналтгүй зарцуулсан	1	1,104.6			1	1,104.6				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>2,241.2</b>	<b>2</b>	<b>370.0</b>	<b>3</b>	<b>1,871.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Тайлант хугацаанд байршуулвал зохих мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулаагүй..	1	211,703.8			1	211,703.8				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>211,703.8</b>	-	-	<b>1</b>	<b>211,703.8</b>	-	-	-	-